



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/31

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтууд, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Их тойруу-2-210а тоот)-т байршилтай иргэн Будхүү овогтой Туяа (ЗЮ:79030707)-ын орон сууцны зориулалттай 80 м.кв (0,008га) газрыг иргэн Цэнд овогтой Сугирсүрэн (ЗЮ:65041667)-д зориулалтаар нь шилжүүлж 11 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/297 дугаар захирамжийн иргэн Б.Туяа-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000025499 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481213466